



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 8/106

Ховд


Г.Сүрэнжавыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.1.2, Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 88 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтнээр Галаагийн Сүрэнжавыг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Галаагийн Сүрэнжавт албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргийг хариуцуулан удирдлага, арга зүйгээр ханган ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх)-д үүрэг болгосугай.

3. Г.Сүрэнжавыг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТЗ-5-1 дэх шатлал буюу 642388 төгрөг (зургаан зуун дөчин хоёр мянга гурван зуун наян найм)-өөр цалинг бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.



ДАРГА

Д.ЭНХБОЛД

8400 03 0882
Tush B/106 Am